



## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2020 оны  
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн  
тайлангийн аудит

Аудитын код: БУА-2021/124/СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.bulgan@audit.mn](mailto:www.bulgan@audit.mn)

Булган аймаг  
2020 он

Булган аймаг дахь Төрийн аудитын газрын  
тэргүүлэх аудитор: Д.Анхбаяр  
Утас:90900910 Цахим хаяг: Ankhbayard@audit.gov.mn  
Аудитын менежер: Ж.Энхцоодол  
Утас: 99057478 Цахим хаяг: Enhtsoodolj@audit.gov.mn  
Гэрээт аудитор: П.Эрдэнэзул  
Утас:99812414 Цахим хаяг: Erdenezulp@audit.gov.mn

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

## Агуулга

---

1.Төрийн аудитын санал, дүгнэлт .....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	9
3.Аудитын тайлан.....	11
3.1. Ерөнхий зүйл .....	11
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй .....	11
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт .....	11
3.4. Материаллаг байдал .....	11
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	12
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт .....	12
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	13
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	13
3.9. Аудитын илрүүлэлт.....	14
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил .....	14
Аудитын зөвлөмж.....	14
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд .....	14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....	15

## 1.Төрийн аудитын санал, дүгнэлт



### БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

63082 Булган аймаг, Булган сум, Жаргалант баг,  
Утас: 7034-2580, Факс: 7034-2580

2021.02.18 № 57

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_ Т

ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН  
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ДАРГА  
Н.БАТЖАРГАЛ ТАНАА

#### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

#### Зөрчилгүй санал дүгнэлт

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

#### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

006020122

### Үүрэг, хариуцлага

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллага үүрэг юм.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.АНХБАЯР

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

ХЭДСан

СТ-1А

### САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>1191899348.00</u></b>	<b><u>1381803568.00</u></b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	1191899348.00	1381803568.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	1937500.00	190000.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	1189961848.00	1381613568.00
3351	Байгууллагаас авах авлага	259200.00	0.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	1189702648.00	1381613568.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>1191899348.00</u></b>	<b><u>1381803568.00</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>0.00</b>	<b><u>79707250.00</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	0.00	79707250.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	0.00	79707250.00
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	0.00	79707250.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг		79707250.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>1191899348.00</u></b>	<b><u>1302096318.00</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	1191899348.00	1302096318.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	1191899348.00	1302096318.00
51210	Өмнөх үеийн үр дүн	875533016.00	1191899348.00
51220	Тайлант үеийн үр дүн	316366332.00	110196970.00
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>1191899348.00</u></b>	<b><u>1381803568.00</u></b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

ХЭДСан

СТ-2А

### САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1046628000.00</b>	<b>571249220.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>7128000.00</b>	<b>5166720.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	7128000.00	5166720.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	7128000.00	5166720.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7128000.00	5166720.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1039500000.00</b>	<b>566082500.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	1039500000.00	309948000.00
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	1039500000.00	309948000.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	0.00	256134500.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	0.00	5134500.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	251000000.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>730261668.00</b>	<b>461052250.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>730261668.00</b>	<b>461052250.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	4000000.00	2694800.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	4000000.00	1998800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4000000.00	1998800.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	0.00	696000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		696000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	726261668.00	458357450.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	340705968.00	216188090.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	340705968.00	216188090.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	7128000.00	5433780.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	7128000.00	5425920.00
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		7860.00

2134	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	81884672.00	13399000.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	81884672.00	12500.00
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		13386500.00
2135	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	296543028.00	223336580.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	296543028.00	223336580.00
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>316366332.00</b>	<b>110196970.00</b>
5	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>316366332.00</b>	<b>110196970.00</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

ХЭДСан

СТ-2А

#### МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>1348458368.00</b>	<b>793097500.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>305608528.00</b>	<b>227015000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	305608528.00	227015000.00
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	305608528.00	227015000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	298480528.00	221848280.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7128000.00	5166720.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1042849840.00</b>	<b>566082500.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	1042849840.00	309948000.00
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	1039500000.00	309948000.00
131009	Оны эхний үлдэгдлээс санхүүжих	3349840.00	0.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	0.00	256134500.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	0.00	5134500.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	251000000.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>1348458368.00</b>	<b>793097500.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1348458368.00</b>	<b>793097500.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>4000000.00</b>	<b>2694800.00</b>
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	4000000.00	1998800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4000000.00	1998800.00

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	696000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		696000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1344458368.00</b>	<b>790402700.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	956965168.00	549980840.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	956965168.00	549980840.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	7128000.00	5433780.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	7128000.00	5425920.00
213304	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		7860.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	83822172.00	13399000.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	83822172.00	12500.00
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		13386500.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	296543028.00	221589080.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	296543028.00	221589080.00
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	0.00	0.00
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

ХЭДСан

СТ-4А

#### ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2019 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	0.00	1,191,899,348.00	1,191,899,348.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	1,191,899,348.00	1,191,899,348.00
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	1,191,899,348.00	1,191,899,348.00
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	0.00	1,191,899,348.00	1,191,899,348.00
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	1,191,899,348.00	1,191,899,348.00
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	110,196,970.00	110,196,970.00
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	1,302,096,318.00	1,302,096,318.00

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ТГ

### ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	0.00	0.00	725595600.00	301683500.00
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	0.00	0.00	725595600.00	301683500.00
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	0.00	0.00	1000000.00	1696000.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	0.00	0.00	1000000.00	1000000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.00	0.00	1000000.00	1000000.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	0.00	0.00	0.00	696000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	0.00	0.00	0.00	696000.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	0.00	0.00	724595600.00	299987500.00
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	0.00	0.00	724595600.00	299987500.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	0.0	0.0	724595600.00	299987500.00

## 2.5 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн гүйцэтгэлийн тайлан

НТ-2

### НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>0.00</b>	<b>250992140.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>0.00</b>	<b>250992140.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	0.00	998800.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	0.00	998800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	998,800.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	0.00	249993340.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	0.00	249993340.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	-	249,993,340.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	0.00	251000000.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	0.00	251000000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	251,000,000.00
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

### **3. Аудитын тайлан**

#### **3.1. Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг төсвийн шууд захирагч Н.Батжаргал танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд үндсэн хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад анхаарах, үндсэн хөрөнгө олж авах, цалингийн тооцооллыг үнэн зөв хийх, батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 25-наас 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Булган аймаг дахь Төрийн аудитын газрын Тэргүүлэх аудитор Д.Анхбаяр хоёр дахь шатны, аудитын менежер Ж.Энхцоодол, ахлах аудитор П.Содном нар анхан шатны хяналтыг тус тус хэрэгжүүлэн, гэрээт аудитор П.Эрдэнэзул хариуцаж гүйцэтгэв.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 01 сарын 22-ны өдрийн 01/50 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй**

Төрийн хууль, ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж, ил тод нээлттэй, шударга байх зарчмыг баримталж, иргэдэд үзүүлэх нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээг чанартай, үр дүнтэй, шуурхай хүргэхэд бидний эрхэм зорилго оршино.

#### **3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт**

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд 2020 онд хяналт шалгалт хийгдээгүй байна.

Улсын төсвийн халамжийн сангийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

#### **3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт

зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны санхүүгийн тайлангийн нийт зардлын 501052.2 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 10021.0 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

### 3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага	1191899.3	1341803.5	149904.2
Өр төлбөр		79707.2	79707.2
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/			
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	1191899.3	1341803.5	149904.2

Тус газар нь өмнөх оны авлага 1191899.3 мянган төгрөг тайлант онд 1381803.5 мянган төгрөгийг болж 199904.2 мянган төгрөгийн авлага үүсгэж ажилласан байна.

Тайлант хугацаанд 79707.2 мянган төгрөгийн өр төлбөр үүсгэж ажилласан байна.

Урт хугацааны өр төлбөр үүсгээгүй байна.

Нийт зардал өмнөх оноос 229019.4 мянган төгрөгөөр буюу 31.3 хувиар буурсан байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт байхгүй байна.

### 3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1741610.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1741610.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 1002931.9 мянган төгрөгөөр бууруулж 738678.1 мянган төгрөгөөр баталсан байна.

#### Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр 724595.6 мянган төгрөг, ХБИ ажиллуулаагүй төлбөрийн орлого 3500.0 мянган төгрөг, Хандив тусламжаар 14082.5 мянган төгрөг нийт 742178.1 мянган төгрөг, төсөв баталснаас 724595.6 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 552000.0 мянган төгрөг, ХБИ ажиллуулаагүй төлбөрийн орлого 5166.7 мянган төгрөг, Хандив тусламжаар 14082.5 мянган төгрөг, эргэн төлөлтийн 221589.0 мянган төгрөг, бусад 259.2 мянган төгрөг нийт 793097.5 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 793097.5 мянган төгрөгийг зарцуулж 240421.7 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн, төсвөөс татаас санхүүжилтийн авлагаар 79707.2 мянган төгрөг тусгасан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 552675.6 мянган төгрөг буюу 69 хувьтай байгаа нь ажлын байрыг дэмжих хөтөлбөр, малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр дутуу /хэмнэсэн/ зарцуулсантай шалтгаалсан байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээ 172595.6 мянган төгрөгөөр санхүүжилттэй холбоотой дутуу зарцуулагдсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

### Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн санхүүжилт 250000.0 мянга, бусад 1000.0 мянган төгрөг нийт 251000.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж зардалд 998.8 мянга, Төрөөс иргэдэд олгох 249993.3 мянган төгрөгийг зарцуулсан байна.

### 3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаандаа оруулсан 145 мэдээлэл, хугацаа хоцроож мэдээлсэн 4 мэдээлэл байна.

### 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 14071.8 мянган төгрөгийн 2 зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	-	-	-				
Албан шаардлага	-		-				
Зөвлөмж	2	14071.8	2	14071.8			
Нийт дүн	2	14071.8	2	14071.8			

/мянган.төг/

### **3.9. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 79707.2 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

#### **Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил**

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн асуудал байхгүй.

#### **Аудитын зөвлөмж**

Аудитаар илэрсэн 79707.2 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

### **3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД**

Байхгүй.

### **4. Менежментийн захидал**

---

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### **Авлага, өглөгтэй холбоотой асуудал**

1.1 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан нь тайлант онд 79707.2 мянган төгрөгийн өглөг шинээр үүсгэн ажилласан байна.

1.2 Өглөг үүсгэсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8."Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" заалтыг зөрчсөн тул зөвлөмж өгөх

1.3 Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8."Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" заалтыг мөрдөж цаашид өглөг үүсгэхгүй ажиллах

1.4 Аудитаар илэрсэн алдаа зөрчлийг төсвийн шууд захирагч хүлээн зөвшөөрсөн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### **АУДИТЫН ТАЙЛАНГ БАТАЛГААЖУУЛСАН:**

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Д.АНХБАЯР

АУДИТЫН МЕНЕЖЕР

Ж.ЭНХЦООДОЛ

#### **АУДИТЫН ТАЙЛАНГ БЭЛТГЭСЭН:**

ГЭРЭЭТ АУДИТОР

П.ЭРДЭНЭЗУЛ

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	<b>2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит</b>	Аудитын код:
2020			САГ-2020/124/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	<b>Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан</b>		Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгуул-лагаас гаргасан шийдэл		
			Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны		
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан нь тайлант онд 79707.2 мянган төгрөгийн өглөг шинээр үүсгэсэн байна	0	Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8."Төсвийг зохистой удирдаж авлага, ер төлбөр үүсгэхгүй байх" заалтыг мөрдөж цаашид өглөг үүсгэхгүй ажиллахаар зөвлөмж өгөх	Дарга Нягтлан бодогч	Н.Батжаргал П.Ундармаа
	<b>ДҮН</b>	<b>0</b>			